



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Мөнххаан сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СБА-2022/75/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Баруун-Урт сум

2022 он

Дарга,

тэргүүлэх аудитор:

М.Нарантуяа

Утас: 99029193 Цахим хаяг: narantuyam@audit.gov.mn

Аудитын менежер:

Г.Даваа

Утас: 99035990 Цахим хаяг: davaag@audit.gov.mn

Ахлах аудитор:

С.Ариунбаяр

Утас: 99076224 Цахим хаяг: ariunbayars@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	13
3.8 Аудитын гол асуудал	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	14
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
4. Аудитын илрүүлэлт	14
4.1 Залруулсан алдаа.....	14
4.2 Төлбөрийн акт.....	15
4.3 Албан шаардлага	15
4.4 Зөвлөмж	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	16

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НА	Нотлох ажил
НББ	Нягтлан бодох бүртгэл
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч



**СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518398, Факс: 70518398
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

2022.08.25 № 66
танай _____-ны № _____-т

СҮХБААТАР АЙМГИЙН МӨНХХААН
СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ЭРХЛЭГЧ С.СЭЛЭНГЭ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Цалингийн зардлаас явуулын амбулаторийн ажлын хөлс олгосон, жолоочийн тооцооны хуудсыг үнэн зөв бичээгүй, кассын тайлан гаргаагүй, бараа материалыг данс бүртгэлд тусгахгүйгээр шууд зардалд илэрхийлсэн, актлах шийдвэр гаргасан хөрөнгийг данс бүртгэлээс хасаагүй зэрэг зөрчлүүд нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон тайлант хугацааны ажил гүйлгээний анги, дансны үлдэгдлийн холбогдох тодруулгын тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, тасалбар болголт, оршин байх, эрх ба үүрэг зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.НАРАНТУЯА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>13,824,220.21</u>	<u>100,873,779.48</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	7,071,718.75
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	7,071,718.75
31211	Төрийн сангийн харилцах	00.00	626,858.52
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	00.00	6,444,860.23
33	АВЛАГА	00.00	73,507,200.00
335	Бусад авлага	00.00	73,507,200.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	73,507,200.00
35	БАРАА МАТЕРИАЛ	13,824,220.21	20,294,860.73
351	Түүхий эд материал	12,242,736.21	14,427,060.73
35110	Тусгай зориулалттай материал	7,801,824.50	1,776,724.50
35130	Эм боох материал	4,440,911.71	12,650,336.23
354	Хангамжийн материал	1,581,484.00	5,867,800.00
35420	Аж ахуйн материал	678,800.00	2,119,300.00
35440	Түлш, шатах тослох материал	167,464.00	00.00
35460	Хүнсний материал	735,220.00	3,748,500.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>309,147,280.76</u>	<u>465,728,829.03</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	309,147,280.76	465,728,829.03
392	Биет хөрөнгө	295,160,480.76	451,742,029.03
39201	Барилга, байгууламж, орон сууц	209,235,075.00	212,745,075.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-12,652,287.60	-18,743,285.52
39203	Авто-тээврийн хэрэгсэл	36,125,234.00	36,125,234.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-16,796,552.04	-19,770,195.48
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	112,889,537.09	306,019,337.09
39206	Хуримтлагдсан элэгдэл	-59,160,354.16	-95,211,330.98
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	38,142,900.00	48,875,900.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-14,015,584.14	-19,152,767.73
39214	Бусад үндсэн хөрөнгө	3,142,250.00	3,142,250.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-1,930,737.39	-2,469,187.35
39217	Ном	181,000.00	181,000.00
393	Биет бус хөрөнгө	13,986,800.00	13,986,800.00
39301	Програм хангамж	1,020,000.00	1,020,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,020,000.00	-1,020,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	13,986,800.00	13,986,800.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>322,971,500.97</u>	<u>566,602,608.51</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>14,075,846.75</u>	<u>00.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	14,075,846.75	00.00
413	Өглөг	14,075,846.75	00.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	2,017,637.75	00.00
4136	Бусад өглөг	12,058,209.00	00.00
41361	Байгууллагад төлөх өглөг	3,395,614.00	00.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	8,662,595.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>308,895,654.22</u>	<u>566,602,608.51</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	308,895,654.22	566,602,608.51
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	333,437,596.80	333,437,596.80

Мөнххаан сумын ЭМТ-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

51101	Өмч: - төрийн	333,437,596.80	333,437,596.80
512	Хуримтлагдсан үр дүн	-57,234,937.06	200,472,017.23
51210	Өмнөх үеийн үр дүн	-57,234,937.06	-57,234,937.06
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	257,706,954.29
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	32,692,994.48	32,692,994.48
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>322,971,500.97</u>	<u>566,602,608.51</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон			/төгрөгөөр/
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	640,606,137.00	1,111,489,009.60
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	561,761,292.00	229,422,960.60
120	Нийтлэг татварын бус орлого	135,222,392.00	155,915,760.60
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	135,093,992.00	149,820,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	135,093,992.00	149,820,000.00
122	Тусламжийн орлого	20,427,800.00	73,507,200.00
122001	Хандив тусламж /дотоод/	00.00	73,507,200.00
122002	Хандив тусламж /гадаад/	20,427,800.00	00.00
123	Улсын төсөв орон нутгийн төсвийн шилжүүлэг	406,111,100.00	00.00
123001	Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого	406,111,100.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	78,844,845.00	446,453,049.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	00.00	435,613,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	12,803,455.00	383,868,819.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,718,855.00	383,729,419.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	84,600.00	139,400.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	20,427,800.00	21,596,000.00
132001	Орон нутгийн төсвөөс санхүүжих	20,427,800.00	21,596,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	45,613,590.00	40,988,230.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	45,613,590.00	40,988,230.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	494,218,412.24	853,782,055.31
21	УРСГАЛ ЗАРДАЛ	494,218,412.24	853,782,055.31
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	488,866,298.41	809,566,229.07
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	299,384,869.48	384,201,465.79
210101	Үндсэн цалин	219,759,304.65	303,222,157.62
210102	Нэмэгдэл	69,077,070.33	65,125,672.82
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	6,145,453.78
210104	Урамшуулал	10,548,494.50	9,708,181.57
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэл	41,688,835.20	66,633,754.42
210201	Тэтгэврийн даатгал	29,829,774.27	53,401,548.48
210202	Тэтгэмжийн даатгал	3,020,493.43	3,326,299.37
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,416,174.77	2,702,046.43
210204	Ажилгүйдлийн даатгал	451,581.19	1,113,276.97
210205	Эрүүл мэндийн даатгал	5,970,811.54	6,090,583.17
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,611,619.96	19,439,570.86
210301	Гэрэл, цахилгаан	6,376,111.16	5,816,827.56
210302	Түлш, халаалт	9,235,508.80	13,622,743.30
2104	Хангамж, бараа материалын зардал	27,068,512.00	57,197,810.00

Мөнххаан сумын ЭМТ-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210401	Бичиг хэрэг	2,805,410.00	11,955,990.00
210402	Тээвэр, шатахуун	21,198,802.00	32,401,720.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,224,500.00	2,451,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	835,600.00	10,389,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,200.00	00.00
2105	Нормативт зардал	60,702,782.83	185,821,759.02
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	46,147,644.83	147,468,099.02
210502	Хоол, хүнс	13,283,130.00	29,191,860.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,272,008.00	9,161,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,926,590.00	27,892,660.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,060,000.00	13,353,800.00
210602	Тавилга	1,898,200.00	14,183,960.00
210604	Урсгал засвар	3,968,390.00	354,900.00
210702	Дотоод албан томилолт	00.00	736,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,930,148.00	32,647,466.05
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,842,698.00	32,647,466.05
210808	Банкны үйлчилгээний хураамж	87,450.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	31,552,940.94	34,995,742.93
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,914,638.00	5,204,491.20
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	26,638,302.94	29,791,251.73
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,352,113.83	44,215,826.24
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,702,800.00	44,215,753.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,702,800.00	44,215,753.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	380,570.04	73.24
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	268,743.79	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	146,387,724.76	257,706,954.29
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	146,387,724.76	257,706,954.29

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	319,450,796.80	00.00	-96,461,704.96	222,989,091.84
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	319,450,796.80	00.00	-96,461,704.96	222,989,091.84
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	815,595,359.01	815,595,359.01
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	333,437,596.80	32,692,994.48	-57,234,937.06	308,895,654.22
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	333,437,596.80	32,692,994.48	-57,234,937.06	308,895,654.22
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	333,437,596.80	32,692,994.48	-57,234,937.06	308,895,654.22
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	257,706,954.29	257,706,954.29
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	333,437,596.80	32,692,994.48	200,472,017.23	566,602,608.51

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон		/төгрөгөөр/	
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	474,955,945.00	882,066,049.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	474,955,945.00	882,066,049.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	396,111,100.00	435,613,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	12,803,455.00	383,868,819.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,718,855.00	383,729,419.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	84,600.00	139,400.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	20,427,800.00	21,596,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	20,427,800.00	21,596,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	45,613,590.00	40,988,230.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	45,613,590.00	40,988,230.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	470,557,745.00	843,741,530.25
21	УРСГАЛ ЗАРДАЛ	470,557,745.00	843,741,530.25
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	464,945,631.17	799,525,706.31
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	299,617,955.73	387,211,404.59
210101	Үндсэн цалин	217,208,444.65	284,855,623.00
210102	Нэмэгдэл	71,861,016.58	82,369,962.30
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	7,025,453.78
210104	Урамшуулал	10,548,494.50	12,960,365.51
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	47,281,495.20	65,561,695.77
210201	Тэтгэврийн даатгал	35,276,734.27	48,988,495.77
210202	Тэтгэмжийн даатгал	3,020,493.43	4,147,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,416,174.77	3,481,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	597,281.19	1,442,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,970,811.54	7,502,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,427,809.96	17,373,026.76
210301	Гэрэл, цахилгаан	6,331,799.96	5,816,827.56
210302	Түлш, халаалт	10,096,010.00	11,556,199.20
2104	Хангамж, бараа материалын зардал	25,784,852.00	54,978,040.00
210401	Бичиг хэрэг	2,847,200.00	7,083,280.00
210402	Тээвэр, шатахуун	19,255,652.00	34,281,560.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,632,000.00	2,335,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,050,000.00	11,278,200.00
2105	Нормативт зардал	55,840,270.28	209,591,916.94
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	42,748,112.28	161,671,176.94
210502	Хоол, хүнс	12,100,250.00	32,477,680.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	991,908.00	15,443,060.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,640,400.00	39,319,160.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,431,300.00	20,329,700.00
210602	Тавилга	2,210,000.00	14,766,560.00
210604	Урсгал засвар	3,999,100.00	4,222,900.00

Мөнххаан сумын ЭМТ-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2107	Томилолт, зочны зардал	00.00	736,000.00
210702	Дотоод албан томилолт	00.00	736,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,930,148.00	11,209,071.05
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,842,698.00	11,209,071.05
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	87,450.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,422,700.00	13,545,391.20
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,422,700.00	13,545,391.20
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,612,113.83	44,215,823.94
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,762,800.00	44,215,750.70
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,762,800.00	44,215,750.70
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	379,680.00	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	379,680.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	890.04	73.24
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	890.04	73.24
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	468,743.79	00.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	468,743.79	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>4,398,200.00</u>	<u>38,324,518.75</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	4,598,200.00	31,252,800.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	4,598,200.00	31,252,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр	4,598,200.00	31,252,800.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	4,598,200.00	31,252,800.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-4,598,200.00</u>	<u>-31,252,800.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-200,000.00	7,071,718.75
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	200,000.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	4,136,932.41	7,071,718.75

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	506,557,700.0	497,570,298.2	8,987,401.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	506,557,700.0	497,570,298.2	8,987,401.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	504,077,700.0	495,154,547.5	8,923,152.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	318,529,900.0	317,550,581.6	979,318.4
210101	Үндсэн цалин	215,194,800.0	215,194,800.0	-
210102	Нэмэгдэл	82,814,700.0	82,369,962.3	444,737.7
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,500,000.0	7,025,453.8	474,546.2
210104	Урамшуулал	13,020,400.0	12,960,365.5	60,034.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	49,348,300.0	49,348,300.0	-
210201	Тэтгэврийн даатгал	32,775,100.0	32,775,100.0	-
210202	Тэтгэмжийн даатгал	4,147,200.0	4,147,200.0	-
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,481,200.0	3,481,200.0	-
210204	Ажилгүйдлийн даатгал	1,442,400.0	1,442,400.0	-

Мөнххаан сумын ЭМТ-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210205	Эрүүл мэндийн даатгал	7,502,400.0	7,502,400.0	-
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,373,100.0	17,373,026.8	73.2
210301	Гэрэл, цахилгаан	5,816,900.0	5,816,827.6	72.4
210302	Түлш, халаалт	11,556,200.0	11,556,199.2	0.8
2104	Хангамж, бараа материалын зардал	25,500,000.0	24,181,980.0	1,318,020.0
210401	Бичиг хэрэг	3,000,000.0	1,864,980.0	1,135,020.0
210402	Тээвэр, шатахуун	19,000,000.0	19,000,000.0	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,500,000.0	2,335,000.0	165,000.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,000,000.0	982,000.0	18,000.0
2105	Нормативт зардал	59,583,500.0	58,605,336.9	978,163.1
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	45,583,500.0	45,173,956.9	409,543.1
210502	Хоол, хүнс	12,500,000.0	11,978,080.0	521,920.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,500,000.0	1,453,300.0	46,700.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,742,900.0	7,054,860.0	1,688,040.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,120,000.0	993,700.0	126,300.0
210602	Тавилга	3,400,000.0	1,838,260.0	1,561,740.0
210604	Урсгал засвар	4,222,900.0	4,222,900.0	-
2107	Томилолт, зочны зардал	1,000,000.0	736,000.0	264,000.0
210702	Дотоод албан томилолт	1,000,000.0	736,000.0	264,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	15,000,000.0	11,559,071.1	3,440,929.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,000,000.0	11,559,071.1	3,440,929.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,000,000.0	8,745,391.2	254,608.8
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,000,000.0	8,745,391.2	254,608.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,480,000.0	2,415,750.7	64,249.3
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,480,000.0	2,415,750.7	64,249.3
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,480,000.0	2,415,750.7	64,249.3
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	506,557,300.0	498,197,156.8	8,360,143.2
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	435,613,000.0	435,613,000.0	-
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	435,613,000.0	435,613,000.0	-
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	21,596,000.0	21,595,926.8	73.2
132001	Орон нутгийн төсвөөс	21,596,000.0	21,595,926.8	73.2
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	49,348,300.0	40,988,230.0	8,360,070.0
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	49,348,300.0	40,988,230.0	8,360,070.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	626,858.5	(626,858.5)

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл	зөрүү
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		377,423,958.8	(377,423,958.8)
21	УРСГАЛ ЗАРДАЛ		377,423,958.8	(377,423,958.8)
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		335,623,958.8	(335,623,958.8)
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		69,660,823.0	(69,660,823.0)
210101	Үндсэн цалин		69,660,823.0	(69,660,823.0)
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		16,213,395.8	(16,213,395.8)
210201	Тэтгэврийн даатгал		16,213,395.8	(16,213,395.8)
2104	Хангамж, бараа материалын зардал		38,125,960.0	(38,125,960.0)
210401	Бичиг хэрэг		12,548,200.0	(12,548,200.0)
210402	Тээвэр, шатахуун		15,281,560.0	(15,281,560.0)
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		10,296,200.0	(10,296,200.0)
2105	Нормативт зардал		154,496,580.0	(154,496,580.0)
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		116,497,220.0	(116,497,220.0)
210502	Хоол, хүнс		20,499,600.0	(20,499,600.0)
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл		17,499,760.0	(17,499,760.0)
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		52,327,200.0	(52,327,200.0)
210601	Багаж, техник, хэрэгсэл		28,366,000.0	(28,366,000.0)
210602	Тавилга		23,961,200.0	(23,961,200.0)
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	4,800,000.0	(4,800,000.0)
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		4,800,000.0	(4,800,000.0)
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	41,800,000.0	(41,800,000.0)
2132	Бусад урсгал шилжүүлэг		41,800,000.0	(41,800,000.0)
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		41,800,000.0	(41,800,000.0)
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	383,868,819.0	(383,868,819.0)
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		383,868,819.0	(383,868,819.0)
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		383,729,419.0	(383,729,419.0)
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		139,400.0	(139,400.0)
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)			-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		6,444,860.2	6,444,860.2

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Мөнххаан сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Ариунбаяр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Даваа, дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Мөнххаан сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 24-ны өдрийн 05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Сумын эрүүл мэндийн төвийн чиг үүргийг Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тухай хуульд харьяа нутаг дэвсгэрийн хүн амын дунд нийгмийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах хөтөлбөр, арга хэмжээг зохион байгуулж, хэрэгжүүлэх, анхан шатны түргэн тусламжийн үйлчилгээ үзүүлэхээр заасан байна.

Тус эрүүл мэндийн төв нь тайлант онд “Хүн амд хүргэх эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах, эрүүл аж төрөх ёсыг төлөвшүүлэх” зорилтыг дэвшүүлэн ажиллажээ.

Мөнххаан сумын эрүүл мэндийн төв 5,045 иргэнд анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлэх үүрэгтэй бөгөөд тайлант онд давхардсан тоогоор 1,470 иргэнд эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлсэн байна. Мөн давхардсан тоогоор 702 иргэн хэвтэн эмчлүүлснээс дотрын өвчний эмгэгээр 208, халдварт буюу ковид 19 цар тахлын улмаас 411, хүүхэд 74 хэвтэн эмчлүүлсэн бол 9 эх тус сумын эмнэлэгт амаржсан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мөнххаан сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл

баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 500,615.7 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 5,006.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 65 хувиар буюу 3,254.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Мөнххаан сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 415,515.5 мянган төгрөгөөр буюу 28.2 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Мөнгөн хөрөнгө	-	7,071.7	7,071.7
Авлага	-	73,507.2	73,507.2
Бараа материал	13,824.2	20,294.9	6,470.7
Үндсэн хөрөнгө	309,147.3	465,728.8	156,581.5
Нийт хөрөнгө	322,971.5	566,602.6	243,631.1
Өглөг	14,075.8		(14,075.8)
Засгийн газрын хувь оролцоо	308,895.7	308,895.7	415,515.6
Тайлант үеийн үр дүн	-	257,706.9	415,515.6
Өр төлбөр, цэвэр өмчийн дүн	322,971.5	566,602.6	243,631.1

Мөнгөн хөрөнгө данс: Тайлант оны төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг дээд шатны төсөвт төвлөрүүлээгүйгээс 7,071.7 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл үлдсэн байна.

Авлага данс: Санхүүгийн тайланд 73,507.2 мянган төгрөгийн авлага бүртгэгдсэн бөгөөд энэ нь эрүүл мэндийн даатгалын сангаас олгох санхүүжилтийг бүрэн олгоогүйтэй холбоотойгоор үүссэн байна.

Бараа материал данс: Төсвийн хөрөнгөөр 285,449.2 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан, дээд шатны төсөв захирагчаас 217.5 мянган төгрөгийн бараа материал үнэ төлбөргүйгээр хүлээн авч, 279,196.0 мянган төгрөгийн материалыг зарцуулсан байна. Бараа материал данс өмнөх оноос 6,470.7 мянган төгрөгөөр өссөн нь ковид19 цар тахлын халдвартай холбоотой эм, эмнэлгийн хэрэгсэл нөөцөлсөн нь нөлөөлж байна.

Үндсэн хөрөнгө данс: Өмнөх оноос 156,581.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд энэ нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 32,452.0 мянга, дээд шатны төсөв захирагчаас 174,920.0 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр хүлээн авч данс бүртгэлд тусгасан нь нөлөөлж байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 435,613.0 мянга, орон нутгийн төсвөөс 21,596.0 мянга, эрүүл мэндийн даатгалын сангаас 49,348.3 мянга нийт 506,557.3 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 498,197.2 мянган төгрөгийн санхүүжилт олгожээ. Төсвийн гүйцэтгэлийн нийт зардлыг 497,570.3 мянган төгрөгөөр илэрхийлж төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл 626.9 мянган төгрөгийг мөнгөн хөрөнгийн үлдэгдлээр илэрхийлжээ.

Төсвийн гүйцэтгэлээр гарсан нийт зардлын 366,898.9 мянган төгрөг буюу 73.7 хувийг цалин хөлс, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл эзэлж байгаа бол 130,671.4 мянган төгрөг буюу 26.3 хувийг байр ашиглахтай холбоотой тогтмол зардал, хангамж, бараа материал, эм бэлдмэл, хоол, хүнсний зардал зэрэг бусад зардалд зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.2 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд Мөнххаан сумын эрүүл мэндийн төвийн нэмэлт санхүүжилтийн дансаар 383,868.8 мянган төгрөг төвлөрч, 377,423.9 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулагдаагүй үлдэгдэл 6,444.8 мянган төгрөгийг мөнгөн хөрөнгийн үлдэгдлээр илэрхийлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Мөнххаан сумын эрүүл мэндийн төв нь 4 зорилтын хүрээнд 56 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг 85.6 хувьтай хэрэгжүүлсэн байна.

Ковид-19 өвчний үед ажиллах улаан бүсийн эмнэлгийг халдварын хэсэг болон амбулаторийн хэсэгт 20 ортойгоор үйл ажиллагаа явуулсан бол халдварын дэгдэлт ихэссэн үед сумын Соёлын төвд 50 ор нэмэлтээр дэлгэсэн байна. Иргэдээс шинжилгээ, сорьц авахад хувийн машинтай иргэдтэй гэрээ байгуулж, ажиллажээ. Суманд 3 сарын сүүлээр Ковид -19 цар тахлын халдварын анхны тохиолдол бүртгэгдэж 12 сарын 31-ны өдрийн байдлаар нийт 1,054 тохиолдол бүртгэгдэж, 411 иргэнийг хэвтүүлэн, 125 өвчтөнийг АНЭ шилжүүлж, 518 хүнд эмийн багц олгож гэрээр эмчилсэн байна.

Байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй байх зарчим, холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний анхаарал татсан болон санхүүгийн тайлангийн хойших үйл явдал, бусад асуудлын талаар тодорхойгүй байдал үүсээгүй байна.

3.8 Аудитын гол асуудал

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдал ажиглагдаагүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим сайтад 126 мэдээллийг хуулийн хугацаанд, 14 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Харин цалингаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 18 зарлагын гүйлгээний 157,721.1 мянга, урсгал санхүүжилтийн 21 гүйлгээний 810,350.5 мянган төгрөгийн мэдээллийг тус тус мэдээлээгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэж байгаа боловч зарим мэдээллийг хангалтгүй байршуулсан гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 331.9 мянган төгрөгийн төлбөрийн акт, 17,809.4 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлж, төсвийн төлөвлөлттэй холбоотой холбоотой 1 зөвлөмж хүргүүлж, биелэлтийг 2021 оны тоот албан бичгээр ирүүлсэн байна. Төлбөрийн акт, албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлсэн байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 110,509.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 29,900.7 мянган төгрөгийн 4 алдааг залруулж, 6,078.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 34,456.8 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 40,073.8 мянган төгрөгийн алдаа зөрчилд зөвлөмж өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. *Ньюремеди ХХК-аас худалдан авсан 9,030.0 мянган төгрөгийн хөрөнгө, бараа материалыг үндсэн хөрөнгийн дансанд нэр төрөл тус бүрээр нь бус бөөн дүнгээр нь бүртгэснийг нэр төрөл бүрээр эдийн засгийн ангиллын дагуу залруулга хийлгэв.*
2. *Худалдан авсан 5,030.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүйг эдийн засгийн ангиллын дагуу бүртгүүлэв.*
3. *Санхүүгийн тайланд нярвын тайлангийн 12,639.2 мянган төгрөгийн үлдээдлийг тусгаагүйг эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авсан анхан шатны баримтаар тулган үлдээдлийг үнэн зөвөөр бүртгүүлэв.*
4. *Хоол, хүнсний үлдээдэл 3,201.5 мянган төгрөгийг санхүүгийн тайланд дутуу илэрхийлснийг тус тус залруулж тайланг үнэн зөвөөр илэрхийлүүлсэн.*

4.2 Төлбөрийн акт

Өмнөх онуудад сумын иргэдэд ЭМГ-аас үзлэг, шинжилгээ хийлгээсний төлбөр 6078,0 мянган төгрөгийг цалингийн төсвөөс олгож /Засаг даргын нөөц сангаас гарах/, төсвийг зориулалт бус зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1¹, 16 дугаар зүйлийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3²-т заасныг зөрчиж үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

4.3 Албан шаардлага

1. Тайлант онд Төсвийн хөрөнгөөр 32,452.8 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, тавилга худалдан авч төсвийн хэмнэлтийн горимыг зөрчсөн байна.
2. Цалингийн зардлаас 2,004.0 мянган төгрөгийн ажлын хөлс олгож, эдийн засгийн ангиллын дагуу зарцуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1³, 16 дугаар зүйлийн 16.5.5⁴, 41 дүгээр зүйлийн 41.2.2⁵, 41.2.3⁶, Засгийн газрын 2021 оны 43⁷ дугаар тогтоолын 1.4⁸ дахь заалтыг зөрчиж, ажил гүйлгээний анги, дансны тодруулгын тохиолдсон байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

3. Шилэн дансны цахим системд цалингаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 18 зарлагын гүйлгээний 157,721.1 мянга, урсгал санхүүжилтийн 21 гүйлгээний 810,350.5 мянган төгрөгийг мэдээллийг тус тус мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4⁹, 6.4.5¹⁰-т заасныг зөрчиж тохиолдсон байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байгаад албан шаардлага хүргүүллээ.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бараа материалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Түлш халаалтын зардлаас 6,687.5 мянган төгрөгийн нүүрс, эм, эмнэлгийн бэлдмэлийн зардлаас 10,796.7 мянган төгрөгийн нэг удаагийн хамгаалах хэрэгсэл тус тус худалдан авч материалын дансанд орлого авч, зарлага болгоогүй шууд зардалд илэрхийлсэн байна.

Өгсөн зөвлөмж: Худалдан авсан материалыг холбогдох эдийн засгийн ангиллын дагуу данс бүртгэлд тусган, захиран зарцуулж байх ;

2. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

¹ төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;

² төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах

³ төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах

⁴ Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах

⁵ батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах;

⁶ төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах

⁷ Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай

⁸ энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх;

⁹ таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг;

¹⁰ цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;

Илрүүлэлт: Авто тээврийн хэрэгсэл дансанд 1998 онд авсан 3,388.8 мянган төгрөгийн хонда маркийн 1, 2012 онд авсан 3,000.0 мянган төгрөгийн хүлэг маркийн 3 мотоциклын ашиглалтыг хугацаа дуусаж, цаашид ашиглагдах боломжгүй, биетээр байхгүй хөрөнгө бүртгэлтэй байна.

Өгсөн зөвлөмж: Дээрх мотоциклын холбогдох материалыг бүрдүүлж байгууллагын өмч хамгаалах зөвлөл болон эрх бүхий байгууллагад хүргүүлж, шийдвэр гаргуулан, акталж данс бүртгэлээс хасах.

3. Мөнгөн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тээвэр шатахууны төсвөөс 16,200.0 мянган төгрөгийн шатах тослох материалын зарцуулалтыг жолоочийн тооцооны хуудсаар үнэн зөв, бүрэн гүйцэт гаргаж тайлагнаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Жолоочийн тооцооны хуудсыг батлагдсан маягтын дагуу иж бүрэн, үнэн зөв хөтөлж, тооцоог бодож, НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйл 13.5-д заасны дагуу холбогдох албан тушаалтан гарын үсэг зурж, баталгаажуулах;

4. Үндсэн хөрөнгийн данс бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг эдийн засгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоогоогүйгээс санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 62 нэр төрлийн хөрөнгө бүртгэлтэй байгаа зөрчил нь УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлд тусгасан "Хөрөнгийн үлдэх өртөг ба ашиглалтын хугацааг наад зах нь санхүүгийн жил бүрийн эцэст хянаж үзэх ба хэрэв хүлээлт нь өмнөх тооцооллоос өөр байвал уг өөрчлөлтийг УСНББОУС 3 тооцооллын өөрчлөлтийн дагуу тайлагнана" заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгийн эдийн засгийн нас буюу ашиглах хугацааг тухайн хөрөнгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоож, УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлийг мөрдөж ажиллах;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 6 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Мөнххаан ЗДТГ	11	110,509.3	4	29,900.7	1	6,078.0	2	34,456.8	4	40,073.8
	ДҮН	11	110,509.3	4	29,900.7	1	6,078.0	2	34,456.8	4	40,073.8